МЭДЭЭ · 2026 оны 6-р сарын 19

“УДИРДАХ АЖИЛТНЫ МАНЛАЙЛАЛ” СЭДЭВТ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгээс “Удирдах ажилтны манлайлал” сэдэвт сургалт зохион байгууллаа.

Энэхүү сургалт нь прокурорын байгууллагын удирдах ажилтнуудын манлайлал, удирдан зохион байгуулах чадавхыг бэхжүүлэх, удирдлагын үр нөлөө, гүйцэтгэлийг дээшлүүлэхэд чиглэгдсэн бөгөөд аймаг, нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын газрын ерөнхий прокурор болон орлогч прокурорууд танхим, цахим хэлбэрээр сургалтад хамрагдсан байна.

Сургалтад Удирдлагын академийн Төрийн инновац, хөгжлийн албаны дарга, доктор, дэд профессор М.Баянмөнх, Хүний нөөцийн удирдлагын тэнхимийн ахлах багш С.Мөнхнаран нар манлайллын онол, үзэл баримтлал, манлайллын хэв маяг, байгууллагын өөрчлөлтийг үр дүнтэй удирдах арга барил, орчин үеийн удирдлагын

чиг хандлага зэрэг сэдвээр мэдээлэл өгч, практикт тулгамдаж буй асуудлуудын талаар санал бодлоо солилцлоо.





